



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 25-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatkhural@parliament.mn
http://www.parliament.mn

2024.11.06 № 33

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД
Л.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

Гадаад ажилчдын ажлын байрны
төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх талаар

Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан. Тус хөтөлбөрийн 6.3.5-д "Хувийн хэвшлийн гадаадаас авах ажиллах хүчний тоонд хязгаарлалт тогтоохгүй байх, хууль тогтоомжийн дагуу ногдуулах ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөхөөр тусгасан байна.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаас Монгол Улсад 2024 онд Хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг эдийн засгийн үйл ажиллагааны 21 салбарын 16 салбарт ажиллах ажилтны тоонд хязгаарлалт тогтоохгүй" гэж, мөн тоон хязгаарлалтаас чөлөөлөгдсөн 16 салбарт ажиллах гадаад ажилчдын ажлын байрны төлбөрийг 50 хувь хөнгөлөх тухай тогтоол гарсан талаар мэдэгдсэн.

Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 149 дүгээр тогтоолоор Монгол Улсад 2024 онд Хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох тухай Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 360 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулсан байх бөгөөд тус тогтоолд гадаадаас авах ажиллах хүчний ажлын байрны төлбөрийг 50 хувь хөнгөлөх талаар зохицуулаагүй байна.

Нөгөөтээгүүр, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.2.5-д Өндөр мэдлэг, ур чадвар бүхий нарийн мэргэжлийн ажиллах хүчний болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг хангах зорилгоор гадаадаас авах ажиллах хүчний тоонд тавих хязгаарлалтыг уян хатан болгох, ажлын байрны төлбөрөөс бүрэн чөлөөлөх бодлого баримтална" гэж тусгагдсан.

Иймд Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2 дах хэсэг, Монгол Улсын Их хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас баталсан Шинэ сэргэлтийн бодлого, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилттэй холбогдуулан Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. 2021 онд батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан гадаадаас авах ажиллах хүчний ажлын байрны төлбөрийг 50 хувь хөнгөлөх хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүднээс авсан арга хэмжээ, гарсан эрх зүйн акт, үр дүн, гүйцэтгэлийн талаар;
2. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасан гадаадаас авах ажиллах хүчний ажлын байрны төлбөрийг бүрэн чөлөөлөх бодлогыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, гүйцэтгэсэн ажлын явцын талаар;

3. 2024-2028 онд улсын хэмжээнд эдийн засгийн үйл ажиллагааны салбар бүрээр ажиллах хүчний хомсдолын тоон төсөөлөл болон авах арга хэмжээний талаар;

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дах хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлнэ үү. Асуулгын хариуг мөн зүйлийн 12.4-т заасны дагуу хэлэлцүүлэх болно.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Д.ЭНХТҮВШИН